

Түүх 7 : Амилалт

Библийн эшлэл
[Иохан 11:25–26]

Есүс Мартад – Амилал ба амь бол Би байгаа юм. Надад итгэдэг нь үхэвч амилна.
Надад амьдрагч хийгээд итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй.
Үүнд итгэж байна үү? гэж асуув.



Есүсийг нас бархад дагалдагч нар болон Түүнийг дагадаг байсан хүмүүс ихэд гуниглан гашуудацгаажээ.

Ромын ахлах тахилч болон удирдагч нар Есүс үхээд гурав хоногийн дараа амилах болно гэсэн үгнээс болж Есүсийг оршуулсан хадан булшийг цэргүүдээр мануулав. Есүс нас бараад гурав дахь хоног болов.

Энэ өдрийн үүрээр Магдалын Мариа болон Иаковын ээж Мариа, Саломе нар булшийг эргэхээр хамт явцгаав.

Тэд Есүсийн биенд анхилуун үнэрт тос түрхэхээр явж байв.

Эмэгтэйчүүд булшинд иртэл булшны ам нээлттэй байхыг харав. Булш хов хоосон байв.

Есүсийн цогцос хаана ч харагдахгүй байв. Гэтэл Есүсийн хэвтэж байсан чулуун дээр нэгэн тэнгэр элч сууж байхыг харав.

Тэнгэр элч тэдэнд ингэж хэлэв. “Та нар бүү айгтун. Загалмайд цовдлогдсон Есүсийг хайж байгааг чинь мэдэж байна.

Есүс амилсан.” Эмэгтэйчүүд баярт мэдээг дуулгах гэж яаран гүйцгээв. Гэтэл замдаа нэг хүнтэй тааралдав.

Тэр нь амилсан Есүс байлаа. Эмэгтэйчүүд ихэд баярлан Есүсийн хөлд сөгдөн унаж, хөлнөөс нь зуурч мэндчилэв.

Тэр өдрийн орой нь дагалдагч нар нь Иерусалимын нэгэн дээврийн өрөөнд цугласан байлаа.

Тэд Ромын цэргүүд ирээд өөрсдийг нь барьчих вий хэмээн ихэд айж хаалгаа сайтар түгжсэн байлаа.

Тэр үед, Есүс дагалдагч нарынхаа өмнө үзэгдэв. Тэд сүнс харсан мэт маш их айн чичирцгээж байв.

Есүс тэдэнд хандан: “Юунд тэгтлээ гайхна вэ? Та нар намайг ингэж харж байгаа нь амилсан гэдэгт эргэлзэж байна үү?

Гараа сунгаад Миний биенд хүрээд үз.” Дагалдагч нар ингэж нэг Түүний амилалтанд итгэв.

Амилсан Есүсийн өмнө өвдөг сөгдөн Түүнд мөргөв. Есүс дагалдагч нартаа ингэж хэлэв.

“Та нар энэ баярт мэдээг дэлхийн бүх хүмүүст дамжуул, зааж, сурга. Тэгээд тэдэнд баптисм хүртээ.

Би үеийн төгсгөл хүртэл та нартай үргэлж хамт байх болно.”

Есүс дэлхийн төгсгөлийг шүүхээр үүл хөлөглөн дахин бууж ирнэ гэж амласан юм.



Бүтээлч байцгаая 1.

Амилалтаараа дамжуулан авралыг төгс болгосон Есүсийг хамтдаа сайн бодож үзэцгээе. Зурагны хажуу хүснэгтэнд байгаа хэлбэрт дүрснүүдийг хэлбэрээр нь хайчилж тохирох хэсэгт байрлуулна уу.



Таван өнцөгт



Дөрвөлжин




Бөөрөнхий



Гурвалжин



Тэгш өнцөгт



- Дараах библийн эшлэлийг дагаж бичээд цээжлээрэй. (Иохан 11:25)

Амилал ба амь бол Би байгаа юм.